



ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2018 оны 05 сарын 21 өдөр

Дугаар А/275

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрхзүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нислэгийн хөдөлгөөний удирдагчийн ажлын байрны дэлгэц 1 ширхэг нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны дарга:	Х.Баттулга	Техник хангалт, навигацийн үйлчилгээний албаны ерөнхий инженер
Нарийн бичгийн дарга:	Б.Санчир	Худалдан авах ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн
Гишүүд:	Ц.Батмөнх	Техник хангалт, навигацийн үйлчилгээний албаны Техникийн төлөвлөлт, инженерингийн хэсгийн технологич инженер
	Б.Цогоо	Монголын аэронавигацийн инженер техникийн ажилтнуудын холбооны гишүүн
	Х.Болор-Эрдэнэ	Үйлдвэрчний эвлэлийн хорооны төлөөлөл

2. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хороо /Х.Баттулга/-нд даалгасугай.

3. Тендер болон сонгон шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөх, Тендер нээхэд үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг гаргуулан Дотоод аудитын албанд хүргүүлэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /Б.Санчир/-д үүрэг болгосугай.

ТЭРГҮҮН ДЭД ДАРГА

Б.АЛТАНЦОМ